

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 02 дугаар сарын ~~14~~-ны өдрийн
~~60.~~ дугаар тогтоолын хавсралт

**“МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК” ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

/нэмэлт өөрчлөлт/

Хүчинчилэгийн эхийн үзүүлэлт
сугаар 9013 001030
1022 03 14

Нэг. Нийтлэг үндэслэл

Оюун
Оюун

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, удирдлага, хяналт, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрхийг тодорхойлох, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх болон холбогдох үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.2. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (цаашид “үйлдвэрийн газар” гэх) нь төрөөс мэдээллийн технологи, инновацыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн технологи, инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх, хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулан төлөвшүүлэх, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, үндэсний брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээ бүтээх, гадаад аутсорсингийн үйл ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий өөрт оногдсон хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар мөн.

1.3. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бодлого, чиглэл, хэм хэмжээний хүрээнд үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.

1.4. Үйлдвэрийн газрын өмчлөгч нь төр байх бөгөөд төрийн өмчийн төлөөллийг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

1.5. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын Иргэний хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Инновацын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дүрмийг мөрдөнө.

Хоёр. Үйлдвэрийн газрын оноосон нэр, оршин байх газрын хаяг

2.1. Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын оноосон бүтэн нэр нь “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, товчилсон нэр нь “МТҮП” ТӨААТҮГ байна.

2.2. Үйлдвэрийн газрын байршил нь түүний удирдлагын байрлаж буй, улсын бүртгэлд бүртгүүлсэн хаягаар тодорхойлогдоно. Үйлдвэрийн газрын оршин байгаа газар нь: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Бага тойруу 49.

2.3. Үйлдвэрийн газрын шуудангийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот.

Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо.

Улаанбаатар 14200

Утас: 976-11-327123

Факс: 976-11-312918

2.4. Цахим шуудан: info@itpark.mn

Гурав. Үйлдвэрийн газрын бэлгэдэл, тэмдэг

- 3.1 Үйлдвэрийн газар нь өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.
- 3.2. Бэлгэдэл, барааны тэмдгийн загварыг Захирлын тушаалаар баталж, Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.
- 3.3. Үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ, хэлцлийг захирал баталгаажуулна.
- 3.4. Тэмдгийг үйлдвэрийн газрын Захирлаас итгэмжлэн хариуцуулсан албан хаагч түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

Дөрөв. Үйлдвэрийн газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

- 4.1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэнээс бусад тохиолдолд үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.
- 4.2. Үйлдвэрийн газрын алсын хараа нь экспортын баримжаатай, өндөр технологийн үйлдвэрлэлийг бий болго замаар Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах, мэдээлэл, технологи, инновацыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бус нутгийн хэмжээний парк болоход оршино.
- 4.3. Үйлдвэрийн газрын зорилго нь төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаанд сууриссан инновацын тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах өрсөлдөх чадвар бүхий үндэсний компаниудыг төлөвшүүлэх, мэдээллийн технологийн өндөр ур чадвартай боловсон хүчнийг хөгжүүлэхэд оршино.

4.4 Үйлдвэрийн газар нь дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.4.1. Монгол Улсад мэдээллийн технологид сууриссан аюулгүй, найдвартай, дэвшилтэт нийгмийг бий болгоход гарааны компани, инкубаторын компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, чиглүүлэх, олон улсад өрсөлдөх чадвар бүхий компани, хүний нөөцийг бэлтгэх;

4.4.2. харилцаа холбоо, мэдээллийн технологийн гарааны компани, иргэнд бизнесийн үйл ажиллагаа явуулах таатай орчин бүрдүүлэх, бойжуулах, тэднийг цаашид бие даан хөгжих, зах зээлд бүтээгдэхүүнээ гаргах, инновацыг бүтээхэд нь дэмжлэг үзүүлэх;

4.4.3. төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын мэдээлэл, технологийн хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, олон улсын жишигт нийцсэн ур чадвар, стандартын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх;

4.4.4. дотоод гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, төр, хувийн хэвшилтэй хамтран ажиллах, хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;

4.4.5. мэдээлэл, технологийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломж бүхий орчин, нөхцөлийг бүрдүүлэх, салбарын төвлөрөл бий болгох.

4.5 Үйлдвэрийн газар нь дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагааг эрхэлнэ:

4.5.1. харилцаа холбооны дэвшилтэт технологийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын болон инновацын судалгаа, хөгжүүлэлт хийх:

4.5.1.1. салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төсөл хөтөлбөрийн бодлогын судалгаа, техник эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;

4.5.1.2. харилцаа холбоо, мэдээллийн технологи, сансрын технологи, өргөн нэвтрүүлэг, шуудан, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр суурь, харьцуулсан, хавсарга судалгааг хийх;

4.5.1.3. харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшилтэт технологи /emerging technology/-ийн төлөв байдал, хандлага, хэрэгцээ шаардлагыг судлах, нутагшуулах санал, зөвлөмж боловсруулах;

4.5.1.4. харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшилтэт технологи, инновацын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг олон улсын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, хамтарсан судалгаа хийх;

4.5.2 Инновацын үйл ажиллагаа, гарааны бизнесийг дэмжих:

4.5.2.1. харилцаа холбоо, мэдээллийн технологийн гарааны компанийг бойжуулах, тэдгээрийн хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, үйл ажиллагааг дэмжих;

4.5.2.2. гарааны компаниудын хурдасгуур хөтөлбөр хэрэгжүүлэх /Стартап хурдасгуур хөтөлбөр, Y-Комбинэйтэр, Текстар гэх мэт/;

4.5.2.3. хөдөлгөөнт холбооны технологид суурилсан агуулга хөгжүүлэгчдийг бэлтгэх;

4.5.2.4. инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэх.

4.5.3. Мэдээллийн технологийн чадварыг сайжруулах

4.5.3.1. мэдээллийн технологийн суурь хэрэглээ буюу анхан шатны ур чадварыг хөгжүүлэх /basic skills/

4.5.3.2. мэдээллийн технологийн дунд түвшний ур чадварыг хөгжүүлэх /Intermediate skills/

4.5.3.3 мэдээллийн технологийн ахисан түвшний ур чадварыг хөгжүүлэх /Advanced skills/

4.6 Үйлдвэрийн газар нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг явуулахад холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлснээр тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

Тав. Үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүрэг

5.1. Үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

5.2. Үйлдвэрийн газар нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон нормативт хэмжээнд нийцүүлэн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгууллагын үндсэн зорилтод нийцсэн төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийх эрхтэй.

Зургаа. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээ

6.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 3, 8, 9-д зааснаас гадна дараах эрх хэмжээг хэрэгжүүлнэ.

6.1.1. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн үйлдвэрийн газрын захирлыг томилж, чөлөөлөх;

6.1.2. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үйлдвэрийн газартай гурвалсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ /Цаашид “ОНБХГэрээ” гэх/ байгуулж, гэрээг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай ОНБХГэрээ байгуулах, дүгнэх” журмаар дүгнэнэ;

6.1.3. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг баталж, орон тооны дээд хязгаарыг тогтоох;

6.1.4. үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, арга зүйн удирдлагаар хангах;

6.1.5. үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эзэмшил, хадгалалт, хамгаалалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг батлах;

6.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь үйлдвэрийн газарт хамаарах төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэгч байна.

Долоо. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх хэмжээ

7.1. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах эрх хэмжээг хэрэгжүүлнэ.

7.1.1. үйлдвэрийн газрын захирлыг томилох, захирлыг чөлөөлөх асуудлаар төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал оруулах;

7.1.2. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үйлдвэрийн газрын захиралтай нэмэлт гэрээ байгуулж болно.

7.1.3. төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үйлдвэрийн газартай гурвалсан ОНБХГэрээ байгуулж, гэрээг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай ОНБХГэрээ байгуулах, дүгнэх” журмаар дүгнэнэ;

7.1.4. үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөх;

7.1.5. үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зорилго, чиглэл, ашигт ажиллагааны зорилтод түвшинг тодорхойлсон урт болон ойрын хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, түүний хэрэгжилтийг хангуулан ажиллана.

7.2. үйлдвэрийн газрыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилпана.

7.3. үйлдвэрийн газрын захирлын ОНБХГэрээг дүгнэх, урамшуулалт олгох асуудлаар төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн

захиралтай ОНБХГэрээ байгуулах, дүгнэх" журмын 3.11-д заасны дагуу үйлдвэрийн газрын ажлын тайлангийн үнэлгээг холбогдох материалын хамт дараа оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Найм. Үйлдвэрийн газрын удирдлага

8.1. Үйлдвэрийн газар нь Удирдах зөвлөлтэй байх бөгөөд удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлнө. Удирдах зөвлөл нь 7 гишүүнтэй байх бөгөөд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх 4 гишүүн, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл 3 гишүүн байна.

8.2. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн төрийн бус байгууллагуудын төлөөлөл байна. Удирдах зөвлөлийн дарга нь Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл байна.

8.3. Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.3.1. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр үйлдвэрийн газрын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

8.3.2. үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох;

8.3.3. үйлдвэрийн газрын жил бүрийн бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийг хянах;

8.3.4. үйлдвэрийн газрын жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

8.3.5. үйлдвэрийн газрын захирлыг мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөх

8.3.6. үйлдвэрийн газрын шинээр худалдаж авах, актлах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, шийдвэрлүүлэх;

8.3.7. удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг батлах;

8.3.8. хууль тогтоомж болон энэ дүрмээр тоггоосон бусад бүрэн эрх.

8.4. Үйлдвэрийн газрын дурэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналаар Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

8.5. Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдана. Үйлдвэрийн газрын захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлнө.

8.6. Үйлдвэрийн газрын ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр захирал томилж, чөлөөлнө.

8.7. Захирал нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай ОНБХГэрээ байгуулан ажиллах бөгөөд ОНБХГэрээ байгуулах, дүгнэх, урамшуулал олгох асуудлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай ОНБХГэрээ байгуулах, дүгнэх” журмаар зохицуулна.

8.8. Захирлыг орлох албан тушаалтныг үйлдвэрийн дотоод журамд заасан байна.

8.9. Захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шалгуурыг хангасан, дээд боловсролтой, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажилласан байна.

8.10. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна шүүхээр ял шийтгэгдэж байсан болон нэр хүнд нь үйлдвэрийн үйл ажиллагаанд харшлах этгээдийг захирлаар томилохыг хориглоно.

8.11. Захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу төрийн, хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, тэдгээрийн захиргаанд орж ажиллах, олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэх, үйлдвэрийн хөрөнгөөр бусад этгээдийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргахыг хориглоно.

8.12. Захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 6, 7-д зааснаас гадна дараах үүрэгтэй:

8.12.1. үйлдвэрийн газрын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

8.12.2. үйлдвэрийн газрын бие даасан байдлыг хангаж, чанарын удирдлагын тогтолцоог боловсруулан мөрдүүлэх, түүний хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

8.12.3. энэхүү дүрмийн 8.4-д заасан зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилчдын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг томилох, чөлөөлөх, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, тухайн гэрээ болон хууль тогтоомжийн хүрээнд урамшуулах, хариуцлага хүлээлгэх;

8.12.4. үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд мөрдөх тушаал, заавар, журмыг Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн боловсруулж, батлан мөрдүүлэх, биелэлтийг хангуулах;

8.12.5. гадаад, дотоод болон олон улсын байгууллага, иргэдтэй өөрийн үйл ажиллагааны чиглэлээр холбоо тогтоох, гэрээ хэлцэл байгуулах, шинжлэх ухааны байгууллага, нийгэмлэг, холбоонд гишүүнээр элсэх;

8.12.6. үйлдвэрийн газрын инкубаторын үйлчилгээнд хамрагдах иргэн, баг, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих үүрэг бүхий сонгон шалгаруулах комиссыг тухай бүр томилж ажиллуулах;

8.12.7. тогтвортой ажиллах бүтээлч хамт олныг бүрдүүлж, ажлын чанар, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах;

8.12.8. төсөв, хөрөнгийг төвлөрүүлэх, хөрөнгийг үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд заасны дагуу захирал зарцуулах, төсөв санхүүгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих;

8.12.9 ажилчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх;

8.12.10 үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай байгуулсан Өмч эзэмшлийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд захирал зарцуулах;

8.12.11. үйлдвэрийн газрын эд хөрөнгөтэй холбоотой асуудлаар буюу шинээр худалдан авах болон актлах, худалдах, шилжүүлэх, үндсэн хөрөнгийн асуудлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

8.12.12. түрээсийн хөнгөлөлтийг зах зээлийн нөхцөлөөс хамааран зохих хууль, тогтоомжийн хүрээнд тогтоож, батлан мөрдүүлэх;

8.12.13. үйлдвэрийн газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

8.12.14. үйлдвэрийн газрыг мэргэжил арга зүй, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан, удирдан ажиллах

8.12.15. холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрсөн нөхцөлд үйлдвэрийн газрын үйлчилгээнд хамрагдах иргэн, баг, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах болон хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөх журмыг боловсруулж, батлан мөрдүүлэх.

8.12.16. хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх үүрэг.

8.13. Захирал нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, үйлдвэрийн газрыг төлөөлөх зэргээр үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

8.14. Захирал өөрийн эрх, үүргийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл авч, итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.15. Өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагааны талаар захиралд зөвлөх эрх бүхий захирлын зөвлөл ажиллана. Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг үйлдвэрийн газрын захирал батална.

8.16. Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, үйлчилгээ, дотоод болон үйл ажиллагааны журам, заавар, технологийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг захирал батална.

8.17. Хүндэтгэн үзэх шалтгаангүй гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь эсхүл хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаагүй, байгууллагын хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй бол Захирлыг ажлаас өөрчлөх үндэслэл болно.

8.18. Захирлаас эрх олгосон албан тушаалтан нь өөр аж ахуйн нэгж, байгууллагад давхар ажиллах, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох болон өрсөлдөөнийг хязгаарлах, шударга бус өрсөлдөөнийг дэмжиж ямар нэгэн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Ес. Үйлдвэрийн газрын эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлага

9.1. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан албан тушаалтыг үйлдвэрийн газрын эрх бүхий албан тушаалтанд тооцно.

9.2. Эрх бүхий албан тушаалтан нь хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн

албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэчлэн гаргаж өгөх үүрэгтэй.

9.3. Эрх бүхий албан тушаалтан нь санаатайгаар хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас үйлдвэрийн газарт хохирол учирсан бол хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна.

Арав. Үйлдвэрийн газрын санхүү, бүртгэл, тайлан

10.1 Үйлдвэрийн газрын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

10.1.1. батлагдсан үнэ, тариф, норматив, гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээнээс олсон орлого;

10.1.2. төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу үзүүлсэн ажил, үйлчилгээний орлого;

10.1.3. хандивлагч орнуудын зээл, тусlamж болон буцалтгүй тусlamж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт;

10.1.4. мэдээллийн технологийн инкубатор ажиллуулахад зориулж жил бүрийн улсын төсвөөс олгох хөрөнгө;

10.1.5. дангаар болон хамтран эзэмшдэг оюуны өмч, бүтээлийг эдийн засгийн эргэлтэнд оруулж олсон орлого;

10.1.6. гарааны болон инкубаторын компаниудаас эзэмшиж буй хувь, хувьцаанаас олох орлого;

10.1.7. банкин дахь дансны үлдэгдлийн болон хадгаламжийн хүү;

10.1.9. хууль тогтоомжийн дагуу олгогдсон улсын төсвийн санхүүжилт болон Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санхүүжилт;

10.1.10. хандив, зээл, тусlamж;

10.1.11. хууль тогтоомжкоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

10.2. Үйлдвэрийн газар нь орлогоороо зарлагаа нөхөж, аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллах ба өөрийгөө санхүүжүүлнэ.

10.3. Үйлдвэрийн газар нь өөрийн эд хөрөнгийг үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж ашиглах эрхтэй.

10.4. Үйлдвэрийн газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө олж авах, тэдгээрийг данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

10.5. Эд хөрөнгийн тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох зүйл заалтын дагуу заасан хугацаанд, зохих журмын дагуу явуулж байна.

10.6. Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

10.7. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг сонгон ажиллуулна.

10.8. Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд болон эд хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэл, тооцоонд тавих өөрийн болон хөндлөнгийн хяналтыг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

10.9. Үйлдвэрийн газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн

тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гаргана.

10.10.Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.

10.11.Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

10.12.Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

10.12.1.баланс

10.12.2.үйл ажиллагааны үр дүнгийн тайлан

10.12.3.мөнгөн гүйлгээний тайлан

10.12.4.өмчийн өөрчлөлтийн тайлан

10.12.5.тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин, шагнал урамшуулал;

10.12.6.нэмэлт тайлбар;

10.12.7.санхүүгийн тайлангийн тодруулга.

10.12.8.хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл.

10.13.Үйлдвэрийн газар үйл ажиллагааны болон аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулсан тухайн жилийн самхүүгийн тайланг тайланг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараа жилийн эхний улиралд багтаан тус тус хүргүүлнэ.

10.14.Үйл ажиллагааны тайланд доорх зүйлийг тусгана:

10.14.1. тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүн;

10.14.2. тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;

10.14.3.тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын албан тушаалтан, ажилтан нарт олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээ;

10.14.4.шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар.

10.15.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу үйлдвэрийн газар нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 3 дугаар сарын 01-ний дотор аудитын дүгнэлт хийлгэнэ.

10.16.Захирал санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудиторыг сонгон гэрээний үндсэн дээр ажиллуулж болно.

Арваннэг. Үйлдвэрийн газрын хяналт, шалгалт

11.1. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын үйл ажиллагаа, ажиллах журмыг захирал батална.

11.2. Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад тавих хяналт нь эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх мэргэжлийн хяналт, дотоодын хяналтаас бүрдэнэ.

11.3. Захирал нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг удирдах дээд байгууллагын өмнө хариуцна.

11.4. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулна.

11.5. Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт болон санхүүгийн үйл ажиллагаанд ТӨБЗГ, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж удирдлагаар хангана.

11.6. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг няглан бодогч хариуцна.

Арванхоёр. Үйлдвэрийн газрын бичиг баримтыг хадгалах

12.1. Үйлдвэрийн газар нь албан хэрэг хөтлөлт, хадгалалт, архивын нийтлэг журмыг мөрдөн ажиллах, бөгөөд дараах бичиг баримтыг хадгална:

12.1.1. үйлдвэрийн газрын дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, байгуулах эрх бүхий байгууллагын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификат;

12.1.2. санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмж;

12.1.3. анхан шатны болон няглан бodoх бүртгэлийн баримт, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт;

12.1.4. үйлдвэрлэл, технологи, норм норматив, түүнтэй холбогдох дүрэм, журам, заавар, бусад бичиг баримт;

12.1.5. хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын гаргасан тушаал, шийдвэр;

12.1.6. шаардлагатай бусад баримт бичиг.

12.2. Дээрх бичиг баримтыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивд шилжүүлэх ажлыг зохих журмын дагуу эрхлэн гүйцэтгэнэ.

Арвангурав. Үйлдвэрийн газрыг татан буулгах

13.1. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

13.2. Үйлдвэрийн газрыг Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу татан буулгана.

Арвандөрөв. Бусад

14.1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг хуулиар зохицуулна.

14.2 Энэхүү дүрэм болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.